



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар A/70

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сум Жишиг гудамж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүдэд: Д.Дөмөгтүшиг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

Ж.Батлхагва - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Л.Түвшинжаргал - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн

дарга: Б.Болор-Эрдэнэ - Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Б.Даваадорж/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Болор-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

D/Tush-A/70-Bo